



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012 8801,
Факс: (976) 32 06 33, И-мэйл: admin@hdc.gov.mn,
Вэбсайт: www.hdc.gov.mn

2022-08-01 № 633

танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 5 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ

П.БАТЧУЛУУН



142104000313

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл
/2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/**

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

- Амбулаторийн тусламж, үйлчилгээний хувьд:

Тус эмнэлгийн Хэрх үе судлалын үзлэгийн кабинетэд үзүүлэхээр 7 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа 6 үйлчлүүлэгч байна. Мөн Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчид үзүүлэхээр 9, Чих хамар хоолойн эмчид үзүүлэхээр 5, нүдний даралт хэмжүүлэх болон Булчирхай судлалын эмчид үзүүлэхээр тус бүр 3, Бөөрний эмчид үзүүлэхээр 2 үйлчлүүлэгч тус тус 4-6 хоног хүлээж байна. Тус эмнэлгийн амбулаторийн бусад мэргэжлийн эмчид үзүүлэх хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

-Оношилгооны тусламж, үйлчилгээний хувьд: Эхо оношилгоо хийлгэхээр 2 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж байна. Бусад оношилгооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

-Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хувьд: Улсын нэгдүгээр төв эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг нийт 1005 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна, Үүнд: Нүдний тасагт 384 үйлчлүүлэгч, бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт 289 үйлчлүүлэгч, мэс заслын тасагт 119 үйлчлүүлэгч, урологийн тасагт 100 үйлчлүүлэгч, чих хамар хоолойн тасагт 86 үйлчлүүлэгч тус бүр 3-аас дээш хоног хэвтэх ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд орж байна. Мөн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 15 үйлчлүүлэгч, цусны эмгэг судлалын тасагт 9 үйлчлүүлэгч, бөөрний эмгэг судлалын тасагт 2 үйлчлүүлэгч, уушиг судлалын тасагт 1 үйлчлүүлэгч тус бүр 3-аас дээш хоног хэвтүүлэн эмчлэх ор хүлээсээр байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт 1. УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 3-аас дээш хоногоор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо / тасаг болон хүлээгдлийн хоногоор, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж хоногийн тоо	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа үйлчлүүлэгчийн тоо
Нүдний тасаг	3-6 хоног	17
	7-14 хоног	8
	15-30 хоног	58
	1 сараас дээш	301
	Нийт	384
Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг	3-6 хоног	8
	7-14 хоног	29
	15-30 хоног	42
	1 сараас дээш	210
	Нийт	289
Мэс заслын тасаг	3-6 хоног	23
	7-14 хоног	60
	15-30 хоног	31

	1 сараас дээш	5
	Нийт	119
Урологийн тасаг	3-6 хоног	30
	7-14 хоног	40
	15-30 хоног	30
	1 сараас дээш	
	Нийт	100
Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	20
	7-14 хоног	21
	15-30 хоног	45
	Нийт	86
Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг	3-6 хоног	2
	7-14 хоног	9
	15-30 хоног	2
	1 сараас дээш	2
	Нийт	15
Цусны эмгэг судлалын тасаг	3-6 хоног	1
	7-14 хоног	6
	15-30 хоног	2
	Нийт	9
Бөөрний эмгэг судлалын тасаг	3-6 хоног	2
	Нийт	2
Уушиг судлалын тасаг	3-6 хоног	1
	Нийт	1
Бүгд		1005

2. Хавдар судлалын үндэсний төв

- Амбулаторийн тусламж үйлчилгээний хувьд:

Нийт 386 үйлчлүүлэгч хавдрын амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар 2-с дээш хоног хүлээж байгаа ба тэдний 98% буюу 379 нь 7 ба түүнээс дээш хоногоор мэргэжлийн эмчид үзүүлэхээр хүлээж байна.

Хүснэгт 2. ХСҮТ-ийн амбулаторийн тусламж, үйлчилгээг 7 ба түүнээс дээш хоногоор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо / үзлэгийн кабинетээр, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

	Үзлэгийн кабинетын нэр	7 ба түүнээс дээш хоног мэргэжлийн эмчид үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	77
2	Элэг, цэс, нойр булчирхай	53
3	Ерөнхий мэс засал	45
4	Толгой хүзүүний мэс засал	44
5	Хими	44
6	Хөхний төв	34
7	Элэг судлал	23
8	Ангиографи	22
9	Туяа	18

10	Зүрх судас	14
11	Цээжний хөндийн мэс засал	5
	Бүгд	379

-Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хувьд: Нийт 364 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хэвтэх ор хүлээж байна. Эдгээр үйлчлүүлэгчдийн хамгийн олон буюу 159 үйлчлүүлэгч нь 15-30 хоног, 127 үйлчлүүлэгч нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар, 68 үйлчлүүлэгч нь 7-14 хоног, 10 үйлчлүүлэгч нь 3-6 хоног ор хүлээж байна. Хими эмчилгээ хийлгэхээр хамгийн олон буюу 202 үйлчлүүлэгч ор хүлээж байна. Энэ нь үйлчлүүлэгч 14-21 хоногийн давтамжтай "товлолт" эмчилгээнд хамрагддагтай холбоотой. Мөн ангиографийн тасагт хэвтэхээр 39 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн мэс заслын тасагт хэвтэхээр 27 үйлчлүүлэгч, элэг, цөс, нойр булчирхайн тасагт хэвтэхээр 26 үйлчлүүлэгч 3- с дээш хоногоор ор хүлээсээр байгаа нь их хүлээгдэлтэй тасгуудад орж байна.

Хүснэгт 3. ХСҮТ-д хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг 3-аас дээш хоногоор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо /тасгаар, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

Хэвтүүлэн эмчлүүлэх ор хүлээж буй хоногийн тоо	3 ба түүнээс дээш хоногоор ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо														
	Хавдрын мэс заслын клиник						Хавдрын өвөрмөц эмчилгээний клиник			Хавдрын яаралтай тусламжийн клиник			Нийт үйлчлүүлэгчийн тоо		
	Ерөнхий мэс засал	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасаг	Тархи, хүзүүний мэс засал	Цээжний хөндийн мэс засал	Хөхний төв	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	Туяа	Өдрийн туяа	Хими	Өдрийн хими	Эрчимт	Хөнгөвчлөх		Ангиографи	Дуран
3-6 хоног								9					1		10
7-14 хоног	2	3	1	1	2	2		40				4	11	2	68
15-30 хоног	4	11	1		4	6	9	95				12	10	7	159
1-сараас дээш	4	12	1	1	3	19	1	58				8	17	3	127
Нийт	10	26	3	2	9	27	10	202				24	39	12	364

-ХСҮТ-д оношилгоо хийлгэхээр 115 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа ба тэдгээрийн 110 үйлчлүүлэгч буюу ихэнх нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Хэт авиан оношилгооны хүлээгдэл хамгийн өндөр буюу 65 үйлчлүүлэгч 7-с дээш хоногоор хүлээж байна байна.

Хүснэгт 4. ХСҮТ-д оношилгоо хийлгэхээр 2-с дээш хоногоор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо / кабинетаар, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

Кабинетын нэр	Оношилгоо хийлгэхээр хүлээж буй хоногийн тоо	Оношилгоо хийлгэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
КТГ	4-6 хоног	2
	7-с дээш хоног	9
Рентген харалт	7-с дээш хоног	12
Ходоодны дуран	4-6 хоног	3
	7-с дээш хоног	10
ЭХО	7-с дээш хоног	65
Зүрхний бичлэг	7-с дээш хоног	14
Нийт		115

3. Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн зөвхөн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлтэй байгаа ба нийт 845 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байна. Чих хамар хоолойн тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 455 үйлчлүүлэгч, зүрхний мэс засал, судасны мэс заслын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 282 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тасагт хамаарч байна.

Хүснэгт 5. ШУГТЭ-ийн орны хүлээгдэл / тасгаар, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	3-с дээш хоногоор ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	85
		15-30 хоног	145
		1 сараас дээш	205
		Нийт	455
2	Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасаг	3-6 хоног	30
		7-14хоног	55
		15-30 хоног	107
		1 сараас дээш	90
		Нийт	282
3	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	12
		7-14хоног	13

		15-30 хоног	11
		1 сараас дээш	22
		Нийт	58
4	Мэс заслын тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	18
		Нийт	25
5	Зүрх судасны тасаг	3-6 хоног	8
		15-30 хоног	1
		Нийт	9
6	Мэдрэлийн тасаг	3-6 хоног	2
		7-14хоног	5
		Нийт	7
7	Уушигны тасаг	3-6 хоног	5
		Нийт	5
8	Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг	3-6 хоног	2
		Нийт	2
9	Бөөр судлалын тасаг	3-6 хоног	2
		Нийт	2
	БҮГД		845

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэг, оношилгоо, лабораторийн тасгууд хүлээгдэлгүй байна.

4. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус төвд 2022 оны 7 сарын 28-ний өдрийн байдлаар нийт 531 үйлчлүүлэгч анх удаагаа амбулаториор үзүүлэхээр дугаар авсны 27 үйлчлүүлэгч нь 2-с дээш хоногоор мэргэжлийн эмчид үзүүлэхээр хүлээж байна. Хүүхдийн гэмтэл согогийн кабинетэд үзүүлэхээр нийт 8 хүүхэд, Хүзүү нуруу нугасны кабинет болон Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын кабинетэд үзүүлэхээр тус бүр 5 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хувьд хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд орж байна. Харин оношилгооны хувьд 186 үйлчлүүлэгч MRI /148 үйлчлүүлэгч/, КТГ/38 үйлчлүүлэгч/-ийн оношилгоо хийлгэхээр 3- с дээш хоног хүлээгдэлтэй байна.

Хүснэгт 6. ГССҮТ-д оношилгоо хийлгэхээр 2-с дээш хоногоор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо /оношилгооны төрөл, 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар/

№	Оношлогооны кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	MRI	3-6 хоног	56
		7-14 хоног	92
2	КТГ	3-6 хоног	38
	БҮГД		186

- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хувьд 2022 оны 7 сарын 29-ний өдрийн байдлаар хүлээгдэлтэй тусламж, үйлчилгээ алга байна.
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхэд нярайн төв-2 болон 3 Амаржих газрууд, Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг нь хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.